

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	2
2.1.	Оршил.....	2
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	2
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	3
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	3
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	4
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	5
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	6
	Өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэхээр тогтов.....	6
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	6
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	7
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
2	Менежментийн захидал.....	8
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
3.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
4	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ Т.ТӨРМӨНХ ТАНАА

2019.03.01 № 06/371
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус хүрээлэнгийн захирал Т.Төрмөнх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн хөрөнгө, төсвийн гүйцэтгэлийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангийн талаар зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дүгээр сарын 22-ноос 2019 оны 2 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Лайэн Аудит” ХХК-ийн аудитор П.Сайнцэцэг, Т.Бид-Ялав нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн нь Малын гаралтай түүхий эд боловсруулах, байгаль орчин ба хүний эрүүл мэндэд ээлтэй өндөр технологи хөгжүүлэх, мэдлэгийг баялаг болгох замаар эх орны хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжилд жинтэй хувь нэмэр оруулах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/337 дугаар тушаалаар Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Шинжлэх ухаан технологийн төсөл хэрэгжүүлэх, сургалт, судалгаа явуулах,
- Хөдөө орон нутагт малын гаралтай түүхий эдийг боловсруулах, жижиг дунд үйлдвэрийг бий болгох, эдгээрт тохирсон бага оврын техник тоног төхөөрөмжийг зохион бүтээх, загварыг үйлдвэрлэх,
- Ноос, ноолуурын түүхий эд болон нэхмэл бүтээгдэхүүнд үндэсний стандартын дагуу чанарын сорил шинжилгээ гүйцэтгэх.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Шинжлэх ухаан, технологийн тухай хууль
- Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
- Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиудад өөрчлөлт орсноос бусад хууль тогтоомжид өөрчлөлт ороогүй.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус хүрээлэн нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/40 дүгээр тушаалаар батлагдсан салбарын хэмжээнд мөрдөгдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байна. Одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцэж байна

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтын нэгжгүй ба дотоод хяналтыг байгууллагын удирдлага хэрэгжүүлэн хэвийн ажиллаж байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт болон цэвэр хөрөнгөнөөс материаллаг түвшинг тогтооход материаллаг түвшин өндөр гарч байгаа тул нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн 2018 оны *Нийт зардал* 763,423.7 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 7,634.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	16,419.4	
2	Албан шаардлага өгсөн	1	57,132.0	
	Дүн	4	73,551.4	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэхээр тогтов.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Боловсруулалт хийх ёстой байсан түүхий эд материалыг боловсруулалт хийлгүй шууд зардалд бүртгэж байгаа байдлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал ажиглагдаагүй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, 2 арга хэмжээнд зориулан 2018 онд 431,035.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 430,372.8 мянган төгрөг буюу 99,8 хувьтай нийт дүнгээрээ 662.3 мянган төгрөг хэмнэсэн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудас www.shilendans.gov.mn сайтад 2018 оны сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, хагас жилийн санхүүгийн тайлан, 2019 оны төсвийн төсөл болон 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12 гүйлгээ буюу нийт 65,002.8 мянган төгрөгийн ажил гүйлгээний мэдээллийг байршуулж олон нийтэд ил тод мэдээлсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 57,132.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байна.

Засгийн газрын 2015 оны 27 дугаар тогтоолоор Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа Нэхмэлийн хүрээлэнг Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнтэй нэгтгэсэнтэй холбоотойгоор Шинжлэх ухаан технологийн их сургуулийн ректорын 2015 оны 04 сарын 03-ны өдрийн А/81 дүгээр тушаалаар Нэхмэлийн хүрээлэнгийн өөрийн орлогын харилцах дансны үлдэгдэл 57,132.0 мянган төгрөгийг Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа Үйлдвэр технологийн сургууль руу шилжүүлснийг авлагаар бүртгэж тайлагнасан байсныг шүүхийн шийдвэр гараагүй байхад Шинжлэх ухаан технологийн их сургуулийн удирдах зөвлөлийн 2017 оны 06 сарын 12-ны өдрийн Зөрчил арилгах 13 дугаар тогтоол болон тус хүрээлэнгийн захирлын 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 47 дугаар тушаалаар авлагаас хасч өмнөх үеийн үр дүнг бууруулсан.

Үйлдвэр технологийн сургууль нь 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдөр өглөг үүсгэлгүй бусад орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотойгоор өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Үндсэн хөрөнгийн талаар

3.1.1 Илрүүлэлт:

Төсөв батлагдаагүй байхад 10,208.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө олж бэлтгэсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1.3-т Төрийн өмчид эд хөрөнгийг дараахь хэлбэрээр олж авна. "...эрх бүхий байгууллагын шийдвэрээр худалдан авсан хөрөнгө", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.1-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгийг эрх бүхий байгууллагаас баталсан төсөв болон төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу худалдаж авна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Хууль тогтоомж зөрчсөн байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолыг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах, батлагдсан төсвийн хүрээнд хөрөнгө бэлтгэх, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, баталгаажуулсан.

3.2 Хөрөнгийг зардалд бүртгэсэн талаар

3.2.1 Илрүүлэлт:

Урсгал засварын зардалд 1,234.8 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн бусад эд зүйлсийн зардалд 1,166.9 мянган төгрөг, багаж техник хэрэгслийн зардалд 1,239.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1,000.0 мянган төгрөг, нийт 4,641.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэж заасныг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчигдөх, хөрөнгө дутагдах.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөн ажиллах, цаашид алдааг давтан гаргахгүй байх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, баталгаажуулсан.

3.3 Тайлангуудыг зөрүүтэй илэрхийлсэн талаар

3.3.1 Илрүүлэлт:

Бараа материалын тайлангаар худалдан авсан бичиг хэргийн материалын орлого 4,067.5 мянган төгрөг байхад мөнгөн гүйлгээний тайлангийн бичиг хэргийн материал худалдан авахад төлсөн мөнгө 2,498.5 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал дансны заавар, УСНББОУС-2 мөнгөн гүйлгээний тайлан тус тус зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Мөнгөн гүйлгээний тайлан буруу илэрхийлэгдэх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 388 дугаар тушаал болон УСНББОУС-2-ыг мөрдөж ажиллах, цаашид алдааг давтан гаргахгүй байх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 7 сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>76,815,499.59</u>	<u>102,861,401.00</u>
МӨНГӨН ХӨРӨНГӨ		
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
АВЛАГА		
УРЬДЧИЛГАА	48,761,800.00	88,339,000.00
Урьдчилж гарсан зардал	48,761,800.00	88,339,000.00
Урьдчилгаа тооцоо		
БАРАА МАТЕРИАЛ	28,053,699.59	14,522,401.00
Түүхий эд материал	9,468,895.59	
Тусгай зориулалттай материал	9,468,895.59	
Бэлэн бүтээгдэхүүн	7,474,000.00	7,174,000.00
Хангамжийн материал	11,110,804.00	7,348,401.00
Бичиг хэргийн материал	791,900.00	547,800.00
Аж ахуйн материал	39,100.00	587,201.00
Сэлбэг хэрэгсэл	920,000.00	3,108,400.00
Түлш, шатах тослох материал		
Барилгын засварын материал	3,814,750.00	2,580,000.00
Бусад хангамжийн материал	5,545,054.00	525,000.00
НӨӨЦИЙН БАРАА		
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>774,205,727.86</u>	<u>959,935,887.03</u>
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	00.00	00.00
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	774,205,727.86	959,935,887.03
Биет хөрөнгө	772,170,727.76	896,629,566.85
Барилга, байгууламж, орон сууц	221,836,141.49	486,054,820.00
Хуримтлагдсан элэгдэл	-90,825,140.00	
Авто-тээврийн хэрэгсэл	18,753,179.40	
Хуримтлагдсан элэгдэл	-18,753,179.40	
Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,321,622,204.12	1,276,221,795.67
Хуримтлагдсан элэгдэл	-697,915,627.34	-888,499,112.45
Тавилга, аж ахуйн эд хогшил	41,461,491.61	45,184,521.61
Хуримтлагдсан элэгдэл	-24,301,342.12	-22,625,457.98
Бусад үндсэн хөрөнгө		3,659.00
Хуримтлагдсан элэгдэл		-3,659.00
Ном	293,000.00	293,000.00
Биет бус хөрөнгө	2,035,000.10	63,306,320.18
Програм хангамж	2,420,000.00	2,420,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-384,999.90	-1,088,999.82
Бусад биет бус хөрөнгө	140,000.00	62,115,320.00
Хуримтлагдсан элэгдэл	-140,000.00	-140,000.00

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бусад хөрөнгө /ТӨҮГ/		
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>851,021,227.45</u>	<u>1,062,797,288.03</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>48,761,800.00</u>	<u>00.00</u>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	48,761,800.00	
Урьдчилж орсон орлого	48,761,800.00	
Бусад урьдчилж орсон орлого	48,761,800.00	
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>802,259,427.45</u>	<u>1,062,797,288.03</u>
Засгийн газрын хувь оролцоо	802,259,427.45	1,062,797,288.03
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	126,077,747.68	188,053,067.68
Өмч: - төрийн	126,077,747.68	188,053,067.68
Хуримтлагдсан үр дүн	673,280,186.96	551,566,078.49
Өмнөх үеийн үр дүн	673,280,186.96	724,943,479.77
Тайлант үеийн үр дүн		-173,377,401.28
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,901,492.81	323,178,141.86
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>851,021,227.45</u>	<u>1,062,797,288.03</u>

1.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	826,601,728.00	589,546,264.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	274,497,048.00	47,502,370.00
120	Нийтлэг татварын бус орлого	274,497,048.00	47,502,370.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	274,497,048.00	47,502,370.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	677,700.00	1,500,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	273,819,348.00	46,002,370.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	552,104,680.00	542,043,894.36
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	456,276,200.00	429,535,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	456,276,200.00	429,535,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	95,828,480.00	112,508,894.36
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		33,059,314.36
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		15,517,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	95,828,480.00	63,931,680.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	708,065,546.32	755,866,118.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	708,065,546.32	755,866,118.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	706,293,800.32	750,173,101.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	349,490,997.00	337,143,383.00
210101	Үндсэн цалин	309,984,597.00	298,378,091.00
210102	Нэмэгдэл	24,870,000.00	23,783,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,636,400.00	13,416,700.00
210105	Гэрээт ажлын хөлс		1,565,492.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,847,193.00	39,928,879.00
210201	Тэтгэврийн даатгал	24,765,023.00	27,309,828.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,875,341.00	3,303,687.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,493,016.00	2,168,880.00
210204	Ажилгүйдлийн даатгал	603,627.00	1,485,106.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,110,186.00	5,661,378.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,544,264.00	17,885,638.00
210301	Гэрэл, цахилгаан	3,836,243.00	6,902,432.00
210302	Түлш, халаалт	7,784,913.00	7,581,076.00
210303	Цэвэр, бохир ус	2,923,108.00	3,402,130.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,108,840.00	10,044,989.00
210401	Бичиг хэрэг	1,685,300.00	2,742,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,628,107.00	3,707,200.00
210404	Ном, хэвлэл	117,000.00	125,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,		170,000.00

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,678,433.00	3,300,189.00
2105	Нормативт зардал	650,000.00	2,297,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	650,000.00	2,297,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,158,978.00	19,365,560.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,941,220.00	2,360,020.00
210604	Урсгал засвар	10,217,758.00	17,005,540.00
2107	Томилолт, зочны зардал	2,567,200.00	2,429,512.00
210702	Дотоод албан томилолт	2,567,200.00	2,429,512.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,650,614.00	47,664,531.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45,190,614.00	45,664,531.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	460,000.00	2,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	234,275,714.32	273,413,609.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,901,264.77	25,536,524.59
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	210,374,449.55	247,877,085.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,771,746.00	5,693,016.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	900,000.00	4,408,834.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	900,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		4,408,834.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	871,746.00	1,284,182.36
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	871,746.00	1,284,182.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>118,536,181.68</u>	<u>-166,319,853.69</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		500,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз		500,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,022,905.75	7,557,547.59
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,022,905.75	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		7,557,547.59
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,022,905.75)	-7,057,547.59
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>117,513,275.93</u>	<u>-173,377,401.28</u>

1.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Аудитлагдсан тайлан
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>568,127,074.00</u>	<u>544,043,894.36</u>
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,378,266.00	2,000,000.00
Нийтлэг татварын бус орлого	11,378,266.00	2,000,000.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	11,378,266.00	2,000,000.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	677,700.00	2,000,000.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,700,566.00	
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	556,748,808.00	542,043,894.36
Улсын төвлөрсөн төсвөөс	456,276,200.00	429,535,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	456,276,200.00	429,535,000.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	95,828,480.00	112,508,894.36
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		33,059,314.36
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		15,517,900.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	95,828,480.00	63,931,680.00
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,644,128.00	
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,644,128.00	
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>534,571,396.00</u>	<u>533,834,934.36</u>
УРСГАЛ ЗАРДАЛ	534,571,396.00	533,834,934.36
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	522,299,650.00	528,141,918.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	343,635,125.00	337,143,383.00
Үндсэн цалин	304,128,725.00	298,378,091.00
Нэмэгдэл	24,870,000.00	23,783,100.00
Унаа хоолны хөнгөлөлт	14,636,400.00	13,416,700.00
Гэрээт ажлын хөлс		1,565,492.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,847,193.00	39,928,879.00
Тэтгэврийн даатгал	24,765,023.00	27,309,828.00
Тэтгэмжийн даатгал	2,875,341.00	3,303,687.00
ҮОМШӨ-ний даатгал	3,493,016.00	2,168,880.00
Ажилгүйдлийн даатгал	603,627.00	1,485,106.00
Эрүүл мэндийн даатгал	6,110,186.00	5,661,378.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,544,264.00	17,885,638.00
Гэрэл, цахилгаан	3,836,243.00	6,902,432.00
Түлш, халаалт	7,784,913.00	7,581,076.00
Цэвэр, бохир ус	2,923,108.00	3,402,130.00
Хангамж, бараа материалын зардал	9,217,840.00	10,348,990.00
Бичиг хэрэг	1,785,200.00	2,498,500.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,628,107.00	3,707,200.00

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Ном, хэвлэл	117,000.00	125,000.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		170,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,687,533.00	3,848,290.00
Нормативт зардал	650,000.00	2,297,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	650,000.00	2,297,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	11,105,658.00	20,319,210.00
Багаж, техник, хэрэгсэл	887,900.00	4,548,420.00
Урсгал засвар	10,217,758.00	15,770,790.00
Томилолт, зочны зардал	2,567,200.00	2,429,512.00
Дотоод албан томилолт	2,567,200.00	2,429,512.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	71,718,454.00	87,241,731.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,258,454.00	85,241,731.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	460,000.00	2,000,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	31,013,916.00	10,547,575.00
Бараа үйлчилгээний бусад зардал	31,013,916.00	10,547,575.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,271,746.00	5,693,016.36
Бусад урсгал шилжүүлэг	11,400,000.00	4,408,834.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	900,000.00	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,500,000.00	4,408,834.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	871,746.00	1,284,182.36
Төвлөрүүлэх шилжүүлэг	871,746.00	1,284,182.36
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>33,555,678.00</u>	<u>10,208,960.00</u>
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	33,555,678.00	10,208,960.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	33,555,678.00	10,208,960.00
Дотоод эх үүсвэрээр	33,555,678.00	10,208,960.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	33,555,678.00	10,208,960.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-33,555,678.00</u>	<u>-10,208,960.00</u>
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

1.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	(төгрөгөөр)
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,077,747.68	2,901,492.81	818,606,889.54	947,586,130.03
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-57,131,000.00	-57,131,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			89,061,953.69	89,061,953.69
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,077,747.68	2,901,492.81	673,280,186.96	802,259,427.45
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			51,663,292.81	51,663,292.81
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	126,077,747.68	2,901,492.81	724,943,479.77	853,922,720.26
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		320,276,649.05		320,276,649.05
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн	61,975,320.00	00.00	-173,377,401.28	-111,402,081.28
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	188,053,067.68	323,178,141.86	551,566,078.49	1,062,797,288.03

1.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	431,035,000.00	430,372,750.00	662,250.00	100
21	УРСГАЛ ЗАРДАЛ	431,035,000.00	430,372,750.00	662,250.00	100
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	431,035,000.00	430,372,750.00	662,250.00	100
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	332,348,900.00	332,347,201.00	1,699.00	100
210101	Үндсэн цалин	289,267,900.00	295,147,401.00	-5,879,501.00	102
210102	Нэмэгдэл	25,944,800.00	23,783,100.00	2,161,700.00	92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,636,200.00	13,416,700.00	1,219,500.00	92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,881,700.00	39,358,837.00	522,863.00	99
210201	Тэтгэврийн даатгал	26,687,900.00	26,739,786.00	-51,886.00	100
210202	Тэтгэмжийн даатгал	3,298,400.00	3,303,687.00	-5,287.00	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,638,800.00	2,168,880.00	469,920.00	82
210204	Ажилгүйдлийн даатгал	659,600.00	1,485,106.00	-825,506.00	225
210205	Эрүүл мэндийн даатгал	6,597,000.00	5,661,378.00	935,622.00	86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,463,200.00	14,463,200.00	-	100
210301	Гэрэл, цахилгаан	5,083,200.00	4,913,994.00	169,206.00	97
210302	Түлш, халаалт	7,520,000.00	6,147,076.00	1,372,924.00	82
210303	Цэвэр, бохир ус	1,860,000.00	3,402,130.00	-1,542,130.00	183
2104	Хангамж, бараа материалын зардал	196,800.00	196,800.00	-	100
210401	Бичиг хэрэг	150,000.00	148,500.00	1,500.00	99
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	46,800.00	48,300.00	-1,500.00	103
2107	Томилолт, зочны зардал	2,567,200.00	2,429,512.00	137,688.00	95
210702	Дотоод албан томилолт	2,567,200.00	2,429,512.00	137,688.00	95
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,577,200.00	41,577,200.00	-	100
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,577,200.00	39,577,200.00	-	100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ	431,035,000.00	430,372,750.00	662,250.00	100

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	ҮҮСВЭР				
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	429,535,000.00	428,372,750.00	1,162,250.00	100
131001	Улсын төсвөөс санхүүжих	429,535,000.00	428,372,750.00	1,162,250.00	100
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих				
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,500,000.00	2,000,000.00	-500,000.00	133
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.00	2,000,000.00	-500,000.00	133
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	35.00	35.00		100
620001	Удирдах ажилтан	01.00	01.00		100
620002	Гүйцэтгэх ажилтан	34.00	34.00		100

2 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн	Аудитын код:
2019.02.25			САГ-2019/48/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаа с гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Өмнөх аудитын зөвлөмжөөр өгсөн бусад авлагыг өмнөх үеийн үр дүн рүү хааж залруулах зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй	57.1	Албан шаардлага өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Т.Болормаа
2	Бараа материалын тайлангаар худалдан авсан бичиг хэргийн материал 4.0 сая төгрөг байхад мөнгөн гүйлгээний тайлангийн бичиг хэргийн материал худалдан авахад төлсөн мөнгө 2.4 сая төгрөгөөр тайлагнасан байна.	1.5	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Т.Болормаа
3	4.6 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын зардалд бүртгэсэн байна.	4.6	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Т.Болормаа
4	Төсөв батлагдаагүй байхад 10.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн.	10.2	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Т.Болормаа
	Дүн	73.6			

